



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 5/01

Майхан

Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай

Байгууллагын даргын 2020 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.2.1, 7.2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн Энхболдын Энхцэцэгийг 2022 оны 01 дүгээр сарын 17-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Даваасүрэнгийн Энхтуяаг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн тус сумын Төрийн сангийн мэргэжилтнээр томилсугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: М.Отгонбат (Санхүү албаны дарга)

Гишүүд: Т.Цэндмаа- Архив, бичиг хэргийн эрхлэгч

Г.Оюун- Нярав-үйлчлэгч

4. Ажлыг журмын дагуу хүлээлцэн, тэмдэглэл хөтлөн танилцуулахыг комиссын дарга (М.Отгонбат), тооцоо хийж дуусгахыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БАТ-ЭРДЭНЭ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 5/02

Майхан

О.Ганпүрэвийг ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1, 78.1.3, 78.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Очирдоржийн Ганпүрэвтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан тул 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газрын Мал аж ахуйн мэргэжилтний ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Буянтогтох (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Гишүүд: Т.Цэндмаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Г.Оюун (Нярав, үйлчлэгч)

3. О.Ганпүрэвтэй холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д, ажлыг хүлээлцүүлэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Буянтогтох)-д тус тус үүрэг болгосугай.



Г.БАТ-ЭРДЭНЭ

1060000000:

My Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 8/03

Майхан

Ч.Баярсайханыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.1, 43.3.3, 43.4, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулж томилгоо хийгдэх хүртэл хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй нөхцөл байдлыг харгалзан Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэнээр Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн Чулуунбатын Баярсайханыг 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Ч.Баярсайханд үндсэн цалингийн 40 хувиар тооцож зохих журмын дагуу нэмэгдэл олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.БАТ-ЭРДЭНЭ

1060000000

My Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 5/04

Майхан

Б.Мөнхзулыг ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.8, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтнээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байсан Батболдын Мөнхзул нь өөр ажилд шилжин ажиллахаар болж ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Г.Буянтогтох (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)
Гишүүд: Т.Цэндмаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)
Г.Оюун (Нярав-үйлчлэгч)

3. Б.Мөнхзултай холбоотой тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа), ажлыг журмын дагуу хүлээлцүүлж танилцуулахыг комиссын дарга (Г.Буянтогтох) нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ

10600000001

My Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 5/05

Сант сум

Д.Энхтуяаг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийн түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Даваасүрэнгийн Энхтуяагаар 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн Нийгмийн бодлогын мэргэжилтний ажлыг хавсарган түр томилсугай.

2.Д.Энхтуяад ажил түр орлон гүйцэтгэсний цалинг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлыг хүлээлцүүлэх, тэмдэглэл хөтлөн танилцуулахыг Архив, бичиг хэргийн эрхлэгч (Т.Цэндмаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ

1060000000

D:My.Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 5/04

Сант сум

Ажил хавсран гүйцэтгэхээс чөлөөлж, нэмэгдэл
хөлсийг зогсоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.59 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль, эрх зүйн мэргэжилтэн Галсандашийн Буянтогтохыг сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлаас чөлөөлж, үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл авч байсныг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоосугай

2.Дээрх тушаал гэрсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Г.БАТ-ЭРДЭНЭ

106000001:

D:My.Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 5/08

Сант сум

Э.Эрдэнэчимэгийг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны “Нэр дэвшүүлэх тухай” 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн жинхэнэ албанд анх орсон Эрдэнэ-Очирын Эрдэнэчимэгийн туршилтын хугацаа дууссан тул Сант сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнээр 2022 оны 11 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Э.Эрдэнэчимэгийг ТЗ-4-1 дэх шатлал буюу 615022 (зургаан зуун арван таван мянга хорин хоёр) төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: Ч.Баярсайхан (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
Гишүүд: О.Ганпүрэв (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Г.Оюун (Нярав-үйлчлэгч)



Г.БАТ-ЭРДЭНЭ

106000001

D:My.Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 5/09

Сант сум

Д.Төмөрхуягийг Засаг даргын Тамгын газрын
жолоочоор түр томилох

Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.5, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын жолоочийн түр ажлын байранд ажиллах хүсэлт өгсөн Дашдоржийн Төмөрхуягийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ний өдрөөс эхлэн түр томилсугай.

2.Д.Төмөрхуягийг ТҮ-3 буюу 569585 (таван зуун жаран есөн мянга таван зуун наян тав) төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Энхболд (Майхан багийн Засаг дарга)
Гишүүд: О.Алтангэрэл (Цахиурт багийн Засаг дарга)
Я.Дагмидмаа (Нягтлан бодогч)



Г.БАТ-ЭРДЭНЭ

106000001

D:My.Doc/A4 tushaal/ doc